

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Я.ОТГОНБАЯРЫН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/2018 оны эхний хагас жилийн байдлаар/

1.1.1. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн/ бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Өгсөн үнэлгээ
1	2	3
1. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
Арга хэмжээ-1.1: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх;	Арга хэмжээ-1.1: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх ажлын хүрээнд хэлтсээс зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд хамрагдсан 51 ажилтанд ААНБ, хувь хүний нууцын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөснөөс гадна сумдад хийсэн дотоод хяналтын үеэр сумын Статистик хариуцсан ажилтан, мал эмнэлэг үржлийн тасгийн ажилтнууд болон багийн Засаг дарга нийт 19 ажилтанд Зөрчлийн тухай хуулиас танилцуулсан байна.	
Арга хэмжээ-1.2: “Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх;	Арга хэмжээ-1.2: ----	
Арга хэмжээ-1.3: Тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах;	Арга хэмжээ-1.3: ----	
Арга хэмжээ-1.5: ҮСХ-ны даргын 2017 оны А/203 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар цуглуулж, дамжуулах;	Арга хэмжээ-1.5: ҮСХ-ны даргын 2017 оны А/203 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу өөрийн хариуцсан салбарын мэдээг цаг тухайд нь гарган дамжуулж байна. Үүнд: Аж ахуйн нэгж байгууллагын дэлгэрэнгүй болон хураангуй мэдээ /ААНБ-1, ААНБ-2/ -г жилийн эцсийн байдлаар 250 ААНБ-аас, улирлын мэдээ / шуудан холбоо, худалдаа, зоогийн газар, зочид буудал, мал эмнэлэг, барьцаалан зээлдүүлэх, төрийн бус байгууллага, нийгэм, бие хүнд үзүүлэх, мэргэжлийн түр сургалт, аялал жуулчлал, сүм хийд/ -үүдийг 2 удаа давхардсан тоогоор 163 ААНБ-аас, сар бүрийн мэдээг сум, баг, ААНБ-аас давхардсан тоогоор 76 удаа, нийт 489 мэдээг авч нэгтгэн, шивж, дамжуулсан байна. Сумдад 2018 онд Статистикийн хэлтэст ирүүлэх мэдээ тайлангийн	

1	2	3
	хуваарь, маягтын цуглуулгыг гэрээт ажилтны хамт бэлтгэн хүргүүлээ. Сумд, ААНБ, иргэдээс ирүүлсэн мэдээний тодруулгыг тухай бүр хийж протокол хөтөлж баталгаажуулсан. Эхний хагас уилээр 15 тодруулга, үүнээс худалдааны мэдээнд 7 тодруулга хийсэн байна. Сумд болон ААНБ-аас цуглуулах мэдээний хуваарь, ирцийн бүртгэлийг сар бүрээр гаргаж хэлтсийн даргаар батлуулан мөрдөж ажиллаж хэвшсэн.	
Арга хэмжээ-1.6: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хэлтсийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Арга хэмжээ-1.6: ----	
Арга хэмжээ-1.7: Аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын хэрэгцээнд шаардлагатай захиргааны статистикийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх;	Арга хэмжээ-1.7: Аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын шаардлагатай захиргааны статистикийн мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч, аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулгад оруулж байна. “Сүмбэр хонь” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр “Сүмбэр хонь”-ны холбогдох үзүүлэлтийг 2010-2017 оны байдлаар гаргаж, хэлтсийн 2018 оны 19 тоотойр хүргүүлэв.	
Арга хэмжээ-1.11: Статистикийн мэдээлэл тархаалтын ажлыг өргөжүүлэх;	Арга хэмжээ-1.11: Статистикийн мэдээлэл тархаалтын ажлыг өргөжүүлэх ажлын хүрээнд байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд хамрагдагсдын цахим хаягийг албажуулан авч хариуцсан ажилтанд хүлээлгэн өгсөн болно. Мөн хэрэглэгчийн бүртгэлээр шинээр бүртгэгдсэн 12 иргэний цахим хаягийг мэдээлэл тархах зорилгоор хариуцсан ажилтанд өгсөн байна. Эхний хагас жилийн байдлаар хэрэглэгчийн бүртгэлд 52 иргэн хамрагдаж давхардсан тоогоор 321 тоон үзүүлэлт авсан байна. Хэлтсийн хэмжээнд Статистикийн бүтээгдэхүүн болох танилцуулга, нугалбарыг цахим хаягаар 780 гаруй, хэвлэмэл байдлаар 200 хэрэглэгчид тараасан байна. Хэлтсээс гаргаж буй бүтээгдэхүүн /2017 оны нийгэм, эдийн засгийн танилцуулга, “Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүд”, “Ажил эрхлэлт”, “Хөдөө аж ахуй”, “Аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ” сэдэвт танилцуулгууд болон сар бүрийн нийгэм, эдийн засгийн танилцуулга, инфографикууд, хэвлэлийн бага хурлын мэдээлэл, сэдэвчилсэн инфографикууд/ -ийг хэлтсийн WEB болон FACE хуудсуудад тухай бүр нь байршуулсан болно.	
2. “Анхан шатны мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах, хяналт шалгалтыг өргөжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг дээшлүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
Арга хэмжээ-2.1: Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах;	Арга хэмжээ-2.1: Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу, хугацаанд нь гаргаж, батламжийг ҮСХ-ны холбогдох ажилтанд хүргүүлэв. Авлигатай тэмцэх Газар болон аймгийн төрийн албаны салбар Зөвлөлийн хамтран зохион байгуулсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргахад анхаарах зүйл” сэдэвт сургалтанд хамрагдав.	

1	2	3
<p>Арга хэмжээ-2.2: Эдийн засгийн статистикийн сар, улирал, жилийн мэдээ /ХАА, АҮ, Барилга, тээвэр, ЗБ, ЗГ, Худалдааны зэрэг/ -ний хамралт, үнэн, бодит байдалд хийх хяналтыг бие даан болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;</p>	<p>Арга хэмжээ-2.2: Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу сумдад хийсэн дотоод хяналтын хүрээнд эхний 3 сарын ХАА-н мэдээ болох ХАА-1, ХАА-2, ХАА-3 мэдээнүүдийн хамралт, үнэн, бодит байдалд хяналт хийж зөвлөгөө өглөө. Хяналтанд сум, баг, Мал эмнэлэг, үржлийн тасаг хамрагдсан байна.</p>	
<p>Арга хэмжээ-2.5: Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах;</p>	<p>Арга хэмжээ-2.5: Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн харъяа агентлагуудаас 5 дугаар сард хамтран зохион байгуулсан “Иргэдэд үйлчлэх нээлттэй өдөрлөг”-ийн бэлтгэл ажлын хүрээнд “Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал, 2013-2017 он”, Говьсүмбэр аймгийн хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтүүд, 2013-2017 он”, “Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн зарим үзүүлэлтүүд, 2013-2017 он” сэдэвт нугалбаруудын эхийг бэлтгэж, олшруулж өгөв.</p>	
<p>Арга хэмжээ-2.6: Статистикийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;</p>	<p>Арга хэмжээ-2.6: Статистикийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих зорилгоор хэлтсийн дотоод хяналт шалгалтын журмын хүрээнд 2018 оны дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг 5 заалттайгаар боловсруулан батлууллаа. Төлөвлөгөөний дагуу сумдын Статистик мэдээний явц, үнэн бодит байдал, мал тооллогын үзүүлэлт болон 2016, 2017 онуудын архивын нэгж бүрдүүлэлт дээр хэлтсийн даргаар батлуулсан удирдамжийн хүрээнд хяналт хийж, заавар зөвлөгөө өгөн, хамтран ажиллалаа. Хяналт шалгалтын удирдамжийг ҮСХ-ны 2018 оны 03/301 тоот албан бичигт тусгасан “Орон нутагт явуулсан хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын явцад гарсан нийтлэг алдаа”-г арилгуулахад чиглүүлэн боловсруулсан болно.</p> <p>АЗДТГ-ын хяналт үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс байгууллагын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний зөвлөмжийн хүрээнд “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” боловсруулан ажиллаж биелэлтийг заасан хугацаанд тус хэлтэст хүргүүлэв.</p> <p>Мөн 2017 онд хийгдсэн, аймгийн төрийн захиргааны байгууллагуудын үйлчилгээ, чанар хүртээмжийг тодорхойлох зорилго бүхий “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”-наас гарсан санал зөвлөмжийн хүрээнд “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” боловсруулан ажиллаж байна.</p>	
<p>3. “Статистикийн дүн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, шинжилгээ судалгааны ажлын өргөжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:</p>		
<p>Арга хэмжээ-3.1: Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаар сарын танилцуулга бэлтгэх;</p>	<p>Арга хэмжээ-3.1: 1, 2 дугаар саруудад “Аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга”-ын эхийг бэлтгэн гаргав.</p>	

1	2	3
5. “Статистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх, төв орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
<p>Арга хэмжээ-5.2: Сургалт, семинар зохион байгуулах замаар боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;</p>	<p>Арга хэмжээ-5.2: Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн хэмжээнд дараахь сургалтуудыг зохион байгуулж тайлагнан цахим болон face хуудсаар сурталчиллаа. Хэлтсийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан дотоод сургалтыг “ Хувь хүний болон харилцааны ур чадварыг хөгжүүлэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хууль эрх зүй”, “Статистикийн програмуудыг ашиглах нь” гэсэн 3 багцын хүрээнд 15 удаа, хэлтсээс ААНБ, иргэдэд зориулсан сургалтыг 4 удаа зохион байгуулсан байна. Хэлтсээс зохион байгуулсан 4 сургалтанд 92 иргэн хамрагдсан байна. Хэлтсийн ажилтнуудаас ҮСХ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан 8 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 9 ажилтан хамрагдав. Эдгээр сургалтын 3 нь ҮСХ-ноос, үүнээс 1 сургалт онлайн хэлбэрээр зохион байгуулагдсан байна.</p>	
<p>Арга хэмжээ-5.3: Цаг үеийн шаардлагаар ҮСХ-ноос эдийн засгийн статистик болон хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь цуглуулж, дамжуулах;</p>	<p>Арга хэмжээ-5.3: Байгаль орчны эдийн засгийн данс байгуулахтай холбогдуулан орон нутагт төлсөн байгаль орчны төлбөр төлөлтийн мэдээг 2015, 2016 онуудаар сумдаар гаргаж ҮСХ-нд хүргүүлэв. 1212.mn-ийг баяжуулахад шаардагдах хөдөө аж ахуй, газар тариалангийн үзлэлтүүдийг 1991-2017 оны байдлаар сум, багийн түвшний боломжит үзүүлэлтээр гаргаж ҮСХ-ны холбогдох газарт хүргүүлэв. 2016 оны ААНБ-ын улсын тооллогын “Говьсүмбэр аймгийн тайлан”-гийн эхийг бэлтгэн хугацаанд нь дамжуулсан бөгөөд ҮСХ-ноос ирүүлсэн анхаарах зүйлсийн дагуу тодруулга, засварыг хийж байна.</p>	
<p>Арга хэмжээ-5.5: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Арга хэмжээ-5.5: Хугацаа болоогүй.</p>	
<p>Арга хэмжээ-5.6: Статистикийн бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх;</p>	<p>Арга хэмжээ-5.6: Статистикийн бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2017 оны жилийн эцсийн тодруулгыг мэргэжилтний хамт хийж 2018 оны эхний улирлаар шинээр үүсгэн байгуулагдсан 7 ААНБ-ын мэдээллийг БР 1 маягтаар гарган ҮСХ-нд дамжуулсан. Бизнес регистрийн мэдээллийг хэрхэн авч дамжуулах талаар хэлтсээс хариуцсан ажилтанд заавар зөвлөгөө өгч ажиллалаа.</p>	
<p>Арга хэмжээ-5.7: Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сумын түвшинд сайжруулан үйл ажиллагаандаа ашиглах;</p>	<p>Арга хэмжээ-5.7: Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сумын түвшинд сайжруулах, мэдээллээ бүрэн татаж авах талаар бүртгэлийн ажилтны сургалтын үеэр болон сумдад хийсэн дотоод хяналт шалгалтын үеэр зааж зөвлөлөө. Мөн нас барсны бүртгэлд мэдээлэл нь орсон иргэний үзүүлэлт болон эцгийн нэр солих иргэний мэдээллийг ҮСХ-нд явуулж залруулга хийлгүүлэв.</p>	
Нийт арга хэмжээний биелэлтийн дундаж оноо		

1.1.2. ТУСГАЙЛАН СОНГОСОН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн/ бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Өгсөн үнэлгээ
1	2	3
<p>Арга хэмжээ-1.10: Мал тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах;</p>	<p>Арга хэмжээ-1.10: Хагас жилийн малын түүвэр судалгааг улсын хэмжээнд 2018 оны 6 дугаар сарын 4-нөөс 11-ний хооронд зохион явуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд энэхүү судалгаанд 234 нэгж хамрагдахаар түүвэрлэгдсэн болно. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн тооллогын комиссыг Засаг даргын 2018 оны А/190 тоот захирамжаар байгуулсан байна. Сумдад тооллого явуулах чиг үүрэг, заавар, маягт, зардлыг хуваарилан тараасан. Сүмбэр суманд сумын тооллогын комисстой хамтран тооллогын семинарыг зохион байгуулав. Тооллого хугацаандаа эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар хүндрэл гараагүй болно.</p>	
<p>Арга хэмжээ-3.2: Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэрэглэгчдэд зайлшгүй тархаах танилцуулгыг бэлтгэх;</p>	<p>Арга хэмжээ-3.2: Өөрийн хариуцсан салбарын мэдээллээр “Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн танилцуулга” –ыг өмнөх онуудаас хүснэгт, графикийг нь сайжруулан гаргаж хэрэглэгчдэд цахим хэлбэрээр хүргүүллээ. Энэхүү танилцуулга нь мал аж ахуй, газар тариалан, бусад гэсэн 3 бүлэгтэй бөгөөд танилцуулгад каракуль хонины талаар тодорхой мэдээллүүдийг оруулж өгсөн болно. Танилцуулгыг WEB болон FACE- д байршуулан сурталчилсан болно.</p>	
<p>Арга хэмжээ-4.1: Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах;</p>	<p>Арга хэмжээ-4.1: Хэрэглэгчдэд зориулсан сургалтыг Баянтал суманд 2 удаа зохион байгуулав. Үүнд: Малчдад зориулсан сургалт “Тоон мэдээллийг хаанаас авах вэ” сэдвээр, 34 малчин хамрагдсан, ААНБ-ын дарга, мэдээлэл хариуцсан ажилтнуудад зориулсан “Статистик мэдээллийг хэрхэн ашиглах вэ”, “Цагийн менежмент, төлөвлөлт” зэрэг сэдвүүдээр, 20 ажилтан хамрагдсан байна. Сургалтын тайланг баримтжуулан шалгуур үзүүлэлтэд заасан хугацаанд ҮСХ-ны холбогдох ажилтанд цахимаар хүргүүлж, хэлтсийн WEB болон FACE-д байршуулав.</p>	
<p>Тусгай арга хэмжээний биелэлтийн дундаж оноо</p>		

1.2. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Нэгжийн хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	Жинхэнэ гүйцэтгэл /тоо,чанар,хугацаа,хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Өгсөн үнэлгээ
1	2	3
Дотоод ажил үйлчилгээ 1: Дотоод хяналт хийх;	“Хэлтсийн дотоод хяналтын журам”-ын дагуу 2018 оны төлөвлөгөөг боловруулж батлууллаа. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөт 3 хяналт, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв.	
Дотоод ажил үйлчилгээ 2: Бүтээлч ажил хийх;	Хэрэглэгчийн санал асуулгын маягтыг аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар болон аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас туршлага судлан сайжруулсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар 50 гаруй хэрэглэгчээс санал асуулга авсан байна.	

1.3.МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ

Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ,тэдгээрийн шалгуур үзүүлэлт /тоо,чанар,хугацаа,хүрэх үр дүн/ бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл /тоо,чанар,хугацаа,хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Өгсөн үнэлгээ
Зорилт 1: Англи хэлний боловсролоо дээшлүүлнэ.	Зорилт- 1: ----	
Зорилт 2: Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлнэ.	Зорилт 2: Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх зорилтын хүрээнд хэлтсээс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, хууль эрх зүй” сэдэвт багц сургалтанд бүрэн хамрагдаж эрх зүйн мэдлэгээ дээшлүүллээ.	
Мэдлэг чадвараа дээшлүүлэх арга хэмжээний биелэлтийн дундаж оноо		
НИЙТ ДУНДАЖ ОНОО		

1.4.Тухайн төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба, төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой **хууль тогтоомж, төрийн албаны болон үйлчилгээний стандартыг мөрдөх, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхтэй** холбогдсон үүргийн биелэлтийн талаарх дүгнэлт:

.....

2. Менежерийн үүргийн биелэлт

1.5. Менежерийн хүлээх үүргийн биелэлтийн талаарх төрийн жинхэнэ албан хаагчийн сэтгэл ханамжийн түвшин

1.5.1. Төрийн жинхэнэ албан хаагч гэрээний нөгөө тал болох менежерийн хүлээсэн үүргийн биелэлтийг хэрхэн үнэлж байгаагаа доорх дөрвөлжний аль тохиороод гэж тэмдэглэнэ.

Бага

Дунд зэрэг

Их

1.6. Эрхэлж байгаа ажлынхаа талаарх төрийн жинхэнэ албан хаагчийн сэтгэл ханамжийн түвшин

1.6.1. Одоогийн эрхэлж байгаа ажилдаа хэр зэрэг сэтгэл ханамжтай байгаагаа үнэлж, доорх дөрвөлжний аль тохиороод оход гэж тэмдэглэнэ.

Бага

Дунд зэрэг

Их

3. Тайлангийн баталгаажуулалт

Ажлын гүйцэтгэлээ тайлагнасан төрийн жинхэнэ албан хаагч:

..... / /
(гарын үсэг)

.....
(огноо)

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

4. Гэрээний биелэлтийн үнэлгээ

4.1. Менежер төрийн жинхэнэ албан хаагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

<i>Гэрээний үзүүлэлт</i>	<i>Өгвөл зохих дундаж оноо</i>	<i>Өгсөн дундаж оноо</i>
1	2	3
1. Нийт ажил, үйлчилгээ (гарц)-ний биелэлт	0-30	
2. Тусгай ажил, үйлчилгээ (гарц)-ний биелэлт	0-40	
3. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын биелэлт	0-30	
<i><u>Нийт оноо</u></i>	0-100	

4.2. Менежер гэрээг дүгнэж өгсөн үнэлгээгээ гэж тэмдэглэнэ:

Хүснэгт 5

<i>“А” буюу “Маш сайн”</i>	<i>“В” буюу “Сайн”</i>	<i>“С” буюу “Хангалттай”</i>	<i>“D” буюу “Дутагдалтай”</i>	<i>“F” буюу “Хангалтгүй”</i>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

5. Менежерийн тэмдэглэл:

5.1. Хэрэв төрийн жинхэнэ албан хаагчид “А” буюу “Маш сайн”, эсхүл “D” буюу “Дутагдалтай”, “F” буюу “Хангалтгүй” үнэлгээ өгсөн бол үндэслэл:

.....

5.2. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1)

2)..... Г.М

6. Дараагийн шатны даргын тэмдэглэл

6.1. Менежерийн үнэлгээг: Зөвшөөрсөн

Зөвшөөрөхгүй

6.2. Зөвшөөрөхгүй тохиолдолд:

1) Үндэслэл:

2) Дараагийн шатны даргын үнэлгээ: “...” буюу “.....”

7. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт

7.1. Үнэлгээ өгсөн:

Менежер

..... / /
(албан тушаал) (гарын үсэг)
Тэмдэг

.....
(огноо)

Дараагийн шатны дарга

..... / /
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)

7.2. Үнэлгээтэй танилцсан:

Төрийн жинхэнэ албан хаагч

..... / /
(гарын үсэг)

.....
(огноо)